



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iac.mn, Вэб сайт: http://iac.mn

2022.02.22 № 05/2507  
танай -ны № -т

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23дахь хэсэгт заасныг үндэслэн дараах нэр дэвшигчдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянахад:

1. Энхбаярын Насанбатыг Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар,
2. Галбадрахын Энх-Амарыг Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн даргаар,
3. Дангаагийн Батбаярыг Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн даргаар,
4. Лхагвасүрэнгийн Өлзийсайханыг Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахим засаглалын хэлтсийн даргаар,
5. Энхжаргалын Өнөзаяаг Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Сансырн холбооны хэлтсийн сансрын технологи, үндэсний хиймэл дагуулын асуудал хариуцсан мэргэжилтнээр,
6. Бугаагийн Урангоог Бодлого төлөвлөлтийн газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн салбарын статистик, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтнээр,
7. Энхбаатарын Оюун-Эрдэнийг Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтсийн телевизийн өргөн нэвтрүүлгийн контентын бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтнээр,
8. Нямдоржийн Пүрэвзулыг Төрийн захиргааны удирдлагын газрын төлөвлөгөө тайлангийн асуудал хариуцсан мэргэжилтнээр,
9. Чинбатын Цолмонг Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтнээр,
10. Ганзоригийн Отгонбаярыг Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн төрийн сангийн төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтнээр,
11. Мөнх-Эрдэнийн Хишигдэлгэрийг Төрийн захиргааны удирдлагын газрын архив-бичиг хэргийн мэргэжилтнээр,
12. Ганзоригийн Эрдэнэцэцэгийг Төрийн захиргааны удирдлагын газрын архив-бичиг хэргийн мэргэжилтнээр,
13. Алтангинжийн Батмандахыг Төрийн захиргааны удирдлагын газрын программ хангамж, сүлжээ хариуцсан мэргэжилтнээр,
14. Нямдоржийн Лувсаншаравыг Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах зохион байгуулагчаар,
15. Бадамдоржийн Билэгдэмбэрэлийг Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар,
16. Малтaryн Солонгыг Бодлого, төлөвлөлтийн газрын шуудан, цахим худалдааны бодлого хариуцсан ахлах мэргэжилтнээр,

17. Баяраагийн Ундралыг Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн салбарын хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтнээр,

18. Баатарын Тунгалагийг Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын харилцаа холбооны сүлжээний ашиглалт, үйлчилгээ, технологийн шинэчлэлийн хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтнээр,

19. Батчулууны Лхагвадолгорыг Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дэмжих систем хариуцсан мэргэжилтнээр тус тус томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т "Ерөнхий шалгалтыг төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй, энэ хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан иргэнээс, тусгай шалгалт /тухайн албан тушаалын/-ыг мөн хуулийн 27.1.1, 27.1.2-т заасан төрийн албан хаагчаас ... авна", мөн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзول, журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2-т "Зөвлөл, Салбар зөвлөл нь сонгон шалгаруулалтын тайланг хянаж, шалгалтаар хамгийн өндөр оноо авсан иргэнийг албан тушаалын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлнэ" гэж тус тус заажээ.

Нэр дэвшигч Э.Насанбат, Г.Энх-Амар, Л.Өлзийсайхан, Э.Өнөзаяа, Б.Урангоо, Э.Оюун-Эрдэнэ, Н.Пүрэвзул, Ч.Цолмон, Г.Отгонбаяр, Г.Эрдэнэцэцэг, А.Батмандах, Н.Лувсаншараав нар нь тухайн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад ороогүй, Э.Насанбат, Г.Энх-Амар нар нь албан тушаалын тодорхойлолтод заасан "Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх", Л.Өлзийсайхан нь "Төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн" байхаар заасныг тус тус хангаагүй байна.

Иймд тухайн албан тушаалд ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлага болон Төрийн албаны тухай хууль, бусад салбарын хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцсэн этгээдийн нэр дэвшүүлж Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн томилох асуудлыг шийдвэрлэнэ үү.

Нэр дэвшигч Б.Урангоо нь "Есөн-Эрхэм" ХХК-ийн үүсгэн байгуулагч, захирлаар бүртгэлтэй байх тул тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж, мөн хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт, хориглолтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД

